



БНЧУ-ЫН АРВАН ЗУРШИЛ – II. ХЭСЭГ

1. Уулзалт дээр утсаа дууг хаах/унтраах нь зүйтэй. Боломжтой бол дуудлагыг авахгүй, SMS уншихгүй байх.
2. Уулзалтад хүүхдүүдтэй ирэхгүй байх (хэрэв тэднийг байлцахыг урьдчилан тохиролцоогүй бол).
3. Бусад хүмүүсийн уулзалтыг бүү тасалдуул. Өөрийн уулзах цагаа хүлээнэ үү.
4. Орой, амралтын өдөр, бүх нийтийн баярын/амралтын өдөр ажилчид руу утасдаж болохгүй. Энэ үед таны асуудал шийдэгдэхгүй байх магадлалтай.
5. Танд тусламж/зөвлөгөө хэрэгтэй байна уу? Чех хэлэнд „prosím“, „děkuji“ гэдэг үг ашиглах нь чухал. Тушааж болохгүй, жишээ нь: *udělejte to*.
6. БНЧУ-д жишээлбэл, ноён эмчээ, хатагтай багш, хатагтай захирал, ноён инженер, ноён Новак... дуудах шаардлагатай.
7. Олон нийтийн газар (хүлээлгийн өрөө, хонгил, галт тэрэг, цахилгаан шат...) бусадтай мэндэлж, хүндэтгэлтэй хандаж мөн эелдэг байх (жишээ нь, эмчийн хүлээлгийн өрөөнд, чимээ шуугиан гаргахгүй байх, чанга хөгжим утсан дээрээ тавихгүй байх гм...)
8. Тусламжийг залилан гэж бүү андуур. Ажилчид танд хуулийг тойрч гарах, худал хэлэх, мэдээлэл, баримт бичгийг хуурамчаар үйлдэх зэрэгт туслахгүй.
9. Тохиромжтой хувцас - тухайн нөхцөл байдалд тохирсон хувцас сонгох, жишээлбэл, ажлын ярилцлагад ороход тохиромжтой хувцаслах, театр руу явахдаа албан ёсны хувцастай, даашинз эсвэл костюм өмсөх гэх мэт.
10. Нийтийн тээвэрт үйлчлүүлэхдээ ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж тэмдэглэсэн суудлуудад суухыг хориглоно. Залуучууд ахмад настан, жирэмсэн эхчүүдэд... суудал тавих ёс үйлчилдэг.

